

ТӨВД СУРВАЛЖ ДАХЬ ЦОГТ ХУН
ТАЙЖИД ХОЛБОГДОХ МЭДЭЭ¹

Д. Бүдсүрэн*

Мэдлэг ухааны олон аймаг савын ном бүтээлийг Монголчууд төвд хэл бичгээр туурвисан байдаг билээ. Тэдгээрийн дотор тухайн үеийн түүхэн хэрэг явдал, нэн ялангуяа Монголын түүхнээ холбогдох чухал мэдээ баримт агуулсан ном бүтээл ч цөөнгүй байдаг. Үүн лүгээ нэгэн адил төвдийн эрдэмт лам нарын бүтээл туурвилд ч Монголын түүхнээ холбогдох чухал мэдээ баримт бас арвин буй.

Бид энэ удаад XVII-XIX зууны үед төвд лам нарын туурвисан зохиол бүтээлүүдэд буй халхын Цогт хун тайжид холбогдох зарим мэдээ сэлтийг түүвэрлэн толилуулахыг хичээлээ. Ийн түүвэрлэн өгүүлэхийн учир нь Цогт хун тайжийн үйл хэргийг тухайн үед төвд лам нар хэрхэн үзэж байсныг тодруулахад оршиж байна.

Энэ үеийн түүхэн хэрэг явдлыг тэмдэглэсэн ном судар цөөнгүй тул тэднээс дээжлэн Тавдугаар Далай лам Агванлуvsанжамц, Туган Лувсанчойжиням, Балманбандида нарын туурвисан бүтээл дэх мэдээ сэлтийг түүвэрлэн өгүүлээ.

Тавдугаар Далай лам Агванлуvsанжамц

གངས་ཅན་ཡུལ་གྱི་ས་ལ་སློད་པའི་མཐོ་རི་ས་ཀྱི་རྒྱལ་སྐོན་གཙོ་བོར་བརྗོད་པའི་དབུ་བའི་རྫོགས་ལྗན་

གཞིན་ནུའི་དགའ་ལྷོན་དཔྱིད་ཀྱི་རྒྱལ་མའི་སྤྱད་བྱངས་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།།

“Цастан орны газраа явсан дээд язгуурт хаад түшмэдийг эрхэнд өгүүлсэн төгс төгөлдөр залуусын хурим хаврын хатны дуун эгшиг” сурвалж

Тавдугаар далай лам Агванлуvsанжамц гал могой жил буюу 1617 онд мэндлээд усан нохой

* “Соёмбо” дээд сургууль

¹ Халхын Цогт хун тайжийн тухай тэмдэглэгдсэн түүхэн сурвалжуудаас бид өмнө “Монгол бичгийн түүхэн сурвалжуудад Цогт хун тайжийн тухай тэмдэглэсэн нь” өгүүллийг МУБИС-ийн “Acta historica” эрдэм шинжилгээний сэтгүүлийн 2009 оны дугаарт, “Монгол эрдэмтдийн төвд хэлээр туурвисан бүтээлд Цогт хун тайжийн тухай өгүүлсэн нь” өгүүллийг Антоон Мостаэрт Монгол судлалын төвийн “Оюуны хэлхээ” эрдэм шинжилгээний сэтгүүлийн 2010 I (06) дугаарт тус тус хэвлүүлсэн бөгөөд энэ удаад төвд хүмүүсийн төвд хэлээр туурвисан зарим сурвалжид Цогт хун тайжид холбогдох мэдээг өгүүлсэн болно.

རིམ་པོ་གཉིས་ལྔ་པའི་བསྟན་པ་ལ་གཞི་དཔེ་འཕྲོ་ལ་བྱས་པའི་རྒྱ་མཚན་རྒྱལ་པོ་འདི་ལྟར་དུ་སོན་ཏེ། རིམ་པོ་ཚེ་རི་བསྟན་པ་འབར་ཞིག་གཉིས་པར་དགོངས་ནས་དམག་གི་
དཔལ་ཚེ་པོ་དང་བཅས་རང་ལུ་ལ་ནས་མེ་གླང་གླུ་བ་དང་པོར་མཚོ་ཁར་བྱོན་ཏེ། གཤམ་པ་བཀྲེས་པས་ཚོགས་ལྷན་གྱི་དམག་གི་ཕྱག་བཞི་དང་བཅས་པ་ལྟག་མ་མེད་པར་བཅོམ་སྟེ།
མདོ་སྐད་ཀྱི་སྲོག་སེམས་མཐའ་དག་མངའ་འོག་ཏུ་བརྟུགས།

cha har rgyal pos sog po tsho chen drug gi nang du dus 'khrug bslang par brten. hal ha'i khrod du 'ga' zhid
bros par. dpon po phan tshun nang ma 'chams pa'i rkyen gyis hal ha chog thu rang yul nas spyugs pa mtsho
khar 'ongs nas. a mdo'i sa cha rnam mnga' 'og tu bcug ste. re zhid mang' thang che bar byung bas bstan pa
spyi dang. Khad par ri bo dge ldan pa'i bstan pa la gnod pa ci 'khyol byas pa'l rgyu mtshan rgyal po 'di'i
snyan du son te. rje rin po che'i bstan pa 'ba' zhid gces par dgongs nas dmag gi dpung chen po dang bcas
rang yul nas me glang zla ba dang por mtsho khar byon te. gyul bkyes pas chog thu'i dmag khri phrag bzhi
dang bcas pa lhag ma med par bcom ste. mdo smad kyi phyogs mta' dag mnga' 'og tu bsdus.

*Цахарын хаан бээр монголын зургаан их чуулганы дотор самуун дэгдээсэнд дулдуйдаж,
зарим нэг нь халхад дутаан ирж, ноёд дотор зуураа эс зохилдсон шалтгаанаар халхын
Цогтыг орноосоо үлдэн хөөсөнд тэрээр Хөх нуурт ирж Амдоогийн газар орныг эрхэндээ
оруулав. Нэгэн зуур агуу хүч нь их болсноор шашин ер ба ялангуяа Рибогэданбын шашинд
хорлол хүргэсэн шалтгаан энэхүү хааны сонорт хүрсэн бөлгөө. Тэрээр жэринбүчигийн⁵
шашин ямагтыг энхрийлэн таалснаар цэргийн их өмөг лүгээ сэлт өөрийн орноос өөд болж,
гал үхэр⁶ жилийн анхдугаар сард Хөх нуурт учран байлдаж, Цогтыг дөрвөн түмэн цэргийн
хамт үлдвэргүй дарж, Домадын⁷ зүгийг эрхэндээ хураав⁸” хэмээжээ.*

Эл сурвалжийн мэдээ нь өмнөх сурвалжийн мэдээтэй ижил байна.

Балманбандида རྒྱ་བོད་རྟོར་སོག་གི་ལོ་རྒྱུས་ཉུང་དུར་བཟོད་པ་བྱིས་འཇགས་པའི་འབབ་སྟེགས་བཞུགས་སོ། (rgya bod hor sog gi lo
rgyus nyung dur brjod pa byis 'jug pa'i 'bab stegs bzhugs so)

*“Энэтхэг төвд монголын түүх өчүүхэн өгүүлэх нялхас оруулахын буух суурь оривой”
сурвалж*

སོག་པོ་ཚེ་རི་བསྟན་པ་ལ་གཞི་དཔེ་འཕྲོ་ལ་བྱས་པའི་རྒྱ་མཚན་རྒྱལ་པོ་འདི་ལྟར་དུ་སོན་ཏེ། རིམ་པོ་ཚེ་རི་བསྟན་པ་འབར་ཞིག་གཉིས་པར་དགོངས་ནས་དམག་གི་
དཔལ་ཚེ་པོ་དང་བཅས་རང་ལུ་ལ་ནས་མེ་གླང་གླུ་བ་དང་པོར་མཚོ་ཁར་བྱོན་ཏེ། གཤམ་པ་བཀྲེས་པས་ཚོགས་ལྷན་གྱི་དམག་གི་ཕྱག་བཞི་དང་བཅས་པ་ལྟག་མ་མེད་པར་བཅོམ་སྟེ།
མདོ་སྐད་ཀྱི་སྲོག་སེམས་མཐའ་དག་མངའ་འོག་ཏུ་བརྟུགས།

⁵ Жээ ринбүчи (rje rin po che) – тогтсон таалал тус бүрд өөр өөрийн лам багшийг дуудах цол бөгөөд энд гэлүгбагийн шашныг үндэслэгч Зонхабыг хэлж байна. Д.Бүрнээ, Д.Энхтөр. “Монголын бурханы шашны түүхэн сурвалж”, Улаанбаатар, 2004, тал 55

⁶ Аргын тооллын 1637 он.

⁷ Домад (mdo smad) – Чамдо дүүргийн нэр. Өөр нэр нь Ермотан бөгөөд хөх нуур мужид багтах, хөх нуураас баруун өмнөд хийгээд Мачу голоос урагш орших газар нутгийг хамарсан ерөнхий нэр. Д.Бүрнээ, Д.Энхтөр, “Монголын бурханы шашны түүхэн сурвалж”, Улаанбаатар, 2004, тал 55.

⁸ Д.Бүрнээ, Д.Энхтөр, “Монголын бурханы шашны түүхэн сурвалж”, Улаанбаатар, 2004, тал 47, 66.

ལུངས་པ་ལྟར་བོད་དམག་ལུང་བ་གང་བའི་ཟིང་གིས་སོག་དམག་བོར་ནས་སྐྱིད་ལོད་འགྲིམ་འདྲིའི་ལྷ་ལོ་ལྟག་སྐྱ་འཁྲིགས་ཤིང་ཉི་མ་ལྟག་མདོག་ཤར་བ་འཁོན་སྐྱོན་གྱིས་
 དུས་རྟགས་སུ་ལུང་བསྟན་དང་ལུང་ཆེན་གྱིས་མགྲུང་བཞེས་པ་ཡོད་ཀྱང་མ་གྲིས་ལམ་ས་ལའང་གིས་འཁོན་སྐྱོན་དཔལ་འབྱོར་ལྷན་གྲུབ་ལའང་མཚོ་ཁར་སོང་ན་མ་དང་མེ་
 སྐད་སྐྱེ་ནམས་འཚོམས་པོར་ཨེ་ཡོད་དྲིས་པས་ཀྱང་ལྷ་བདེ་མོ་ཡོད་པོ་མི་འཕྲད་བར་ཆད་ཆེགས་དཔལ་ལྡན་རྣམས་མའི་ལུང་བྱུང་དུ་སྐྱོད་ལའང་དོན་ལ་དམ་ཅན་ཚོས་གྱི་རྒྱལ་བོ་ཁྲིས་དྲེ།
 ཐའི་ཇི་ཁོར་རང་སྐྱོ་སྐད་མཁུ་སྐྱར་ལ་བོག་འཁྲུག་སོགས་བྱུང་ལམ་ཡོད་སྐབས་ཆོག་ཐུས་དགོ་ལུགས་པ་ལ་སྤང་བོ་བྱེད་དགོས་པ་དང་རྒྱལ་བ་ཡབ་སྐུས་ལ་མི་མཇལ་བ་སོགས་
 ས་གྱི་བཀོད་པ་བྱས་ཡོད་ཀྱང་ཁ་ཤོ་ཁ་བ་དང་ཆོར་གསེབ་གྲུབ་ཆེན་གྱིས་འཛིགས་བྱེད་གྱི་སྐོ་ནས་སྤང་སེམས་ཞི་ཞིང་སྤྲོ་བཀོད་བའི་ལས་སྦྱོར་མཛད་པས་འགོད་པ་དང་འ
 གལ་དྲེལ་བ་ཆེན་པོ་དག་ལྟར་ཁང་གསར་དུ་གདན་དྲངས་ཁོར་རང་སྐོ་འགྲུང་ནས་སྐུས་ཀྱང་ཕྱག་མི་འཚོལ་བའི་ནང་ཁྲིམས་བཞིགས་དྲེལ་གྱི་ཕྱག་འཚོལ་ཞིང་བྱིན་སྐྱབས་ལྟ
 ས་བཞུགས་གལ་དུ་བསྐོ་སྐྱོད་བྱས་པ་ལ་སྐབས་སོགས་ཆོས་གཏམ་ལྟས་ལ་བོ་འགའ་ཞིག་ལ་ཆད་པ་བཅད་ནས་ལུགས་ལྟག་བཅུག་པའི་ལུགས་ལྟར་ལོ་ནོར་བུ་དག་ལ་
 འཁྲིལ་ཞིག་བྱུང་བར་སྐོན་སོགས་ལུང་རྒྱལ་བ་བསོད་ནམས་རྒྱ་མཚོའི་སྐྱ་བཞེད་ས་པའི་ཁ་ལུང་ལའོར་བུ་དག་ལ་འཁྲིལ་བྱུང་བ་སོགས་ལུང་བསྟན་པ་དང་བའི་རྟེན་འབྲེ
 ལ་དུ་སོང་བའི་དབེ་དང་མཚུངས་ཚུལ་སོགས་གྲགས་པས་སྐོན་པོ་དའི་ཆིང་དང་འཁྱེད་མར་རབ་འབྱུམས་པ་སོགས་གྱིས་ཆོག་ཐུ་ལ་མི་མངགས་ནས་བུ་ཡམར་ས་ལའང་འདྲི་ཡབ
 གྱི་བཀའ་དང་འགལ་བས་ཇི་ལྟར་བྱེད་དྲིས་པར་བསྐྱེད་བསྐྱེད་གྱིས་སོད་ཅེས་པའི་ལན་བྱུང་བ་སྤར་བས་དཀའ་ཅིས་རྟེན་བཅོམ་པ་དང་དུས་འགྲིག་པས། ཆོག་ཐུ་སྐྱོགས་རྗེས
 མེད་དུ་སོང་། ཆོག་ཐུ་ཡང་རིག་པ་རྣོ་བ་ཞིག་སྟེ།

sog po tsho chen drug gi dpon thams cad rus gcig pas. dmag gral du stabs nyes na ma gtogs 'di 'dra med
 kyeng. srol ngan 'di cha har leg sngan dang. chog thu gnyis kyis btod ces kun gyis ngan du gleng bar byed.
 shing phag la ar sa lang khri dmag bcas 'dam du 'byor. yung shi yi bu'i dpon khag bzhi gcig char bcom. cho
 khar stod du song ba dang 'grig. bu ner bu rin chen dang. karma che ba gnyis bros. karma chung ba dang nom
 chi gnyis bsad. thams cad 'dar rdo 'dar du song. zhy dmar rab 'byams pa dang khong pha bu tshos gtsang ba
 dang gzhang gcig byed. lha sa za dam pa dang. ry sgrenge 'bab rong bas 'dzin. grub mtha' gzhan btang snyoms.
 dge lugs pa ming med du gtong. kar 'brug sbyin bdag byed shom dang. lha rtse dpon mo spre'u dang thang
 chu'i dpe yin shas che yang. dge lugs kyi ser mo ba thams cad bcom pas rang phyogs rnams yang shes lnga
 ba chen po'i rnam thar du yod kyang zhib cha ma nges. dgun smad sog pos gyas ru 'bri gung dang. gyon ru
 gtsang byang brgyud pa dang. byings rnams yar 'brog tu lam btod nas sde gzar lang pas gnam sa 'gas pa
 lta bu'i 'jigs skrag byung nas. bsod names rab brtan gyis lnga ba chen por thugs brtag zhus par. sgyon med
 gsungs pa ltar. bod dmag lung ba gang ba'i zing gis sog dmag thor nas skyid shod 'grim. 'di'i sda lo khug sna
 'khigs shing nyi ma khrag mdog shar ba 'khon ston gyis dus rtags su lung bstan dang. pan chen gyis mgur
 bzes pa yod kyang ma bris. ar sa lang gis 'khon ston dpal 'byor lhun grub la. nga mtsho khar song na pha
 dang e 'phrad. sde rnams 'tshams por e yod dris nas. da lta bde mo yod. ngo mi 'phrad. bar chad che gsungs
 pa ltar. rnying ma'i mthu byad du gleng yang. don la dam can chos kyi rgyal bo khros te. tha'i ji kho rang
 smyos. dmag sgar la thog 'khyug sogs byung. yar yong skabs chog thus dge lugs pa la sdang bo byed dgos pa
 dang. rgyal ba yab sras la mi mjal ba sogs kyi bkod pa byas yod kyang. pha bo kha dang. tsher gseb grub chen
 gyis. 'jigs byed kyi sgo nas. sdang sems zhi zhing spa bkong ba'i las sbyor mdzad pas. bkod pa dang 'gal te.
 lnga ba chen po dga' ldan khang gsar du gdan drangs. kho rang blo 'gyur nas. sus kyang phyag mi 'tshal ba'i
 nang khirms bshigs te. phyag 'tshal zhing byin rlabs zhus. bzhugs gral du bgro gleng byas pa la su bzang sogs
 chos gtam zhus. bal bo 'ga' zhig la chad pa bcad nas. lugs ldug bcug pa'i lugs phung la nor bu dga' 'khil zhig
 byung bar. sngon sog yul du rgyal ba bsod names rgya mtsho'i sku bzhengs pa'i kha lung la. nor bu dga' 'khil
 byung ba. sog yul du bstan pa dar ba'i rten 'brel du song ba'i dpe dang mtshungs tshul sogs grags pas blon po
 da'i ching dang. zhy dmar rab 'byams pa sogs kyis chog thu la mi mngags nas. bu ar sa lang 'di yab kyi bka'
 dang 'gal bas ji ltar byed dris par. bslu thabs kyis sod ces pa'i lan byung ba star bsad. gu shris rta khra bcom
 pa dang dus 'grig pas. chog thu phyogs rjes med du song. chog thu yang rig pa rno ba zhig ste.

9 bal'mang'pandi'tas'brtsams,rgya'bod'hor'sog'gi'lo'rgyus'nyung'ngur'brjod'pa'byis'pa 'jug'pa'i''bab'stegs'bzhug
 s'so, mtsho'sngon'mi'rigs'dpe'skrun'khang, 1990. òàè 137-140.

Монголын зургаан их аймгийн ноёд бүхэн нэгэн овог учраас цэрэг бэлтгээж гэмтэй байснаас бус энэ муу ёсыг Цахарын Лигдэн, Цогт хоёр гаргасан гэж бүгд муушаадаг. Модон гахай¹⁰ жил Арслан түмэн цэрэгтэй Цайдамд ирсэн байна. Юншээбүүгийн дорвон хэсэг ноёдыг нэгэн зэрэг дарж, Чохүрдод-д монгол ирсэнтэй нийлэн Бүнир Ринчэн, Гармачэва хоёр зугтсан аж. Гармачунва, Номч хоёр алагдаж, бүгд тарж бутарч одсон байна. Шуумар Равжамбатай тэрбээр ариун ах дүү бололцож нэгэн ёс номыг үйлдэв. Лхаса-садамба, Радин, Рон нугуудыг эзлэж, бусад ном ёсыг тэгшитгээж Гэлүмбагийн ёсыг нэргүй устгасан байна. Гармава, Вүрүгваа ёсны өглөгийн эзэн болсон бөгөөд Гэлүмбагийн ёстон бүхнийг дарсан тул өөрийн зүг бүхнийг амирлуулсан хэмээн тавдугаар далай ламын намтарт байдаг ч нарийн тодорхой мэдсэнгүй. Өвлийн сүүлээр монголчууд баруун зүгт Брэйгүн, зүүн зүгт хойд Зангаар дайраад Врог тийш зам гаргасанд айгаад Содномравдан тавдугаар далай ламд айлтгасанд гэмгүй хэмээн айлджээ. Төвдийн цэрэг нутаг орныг дүүрэн байсан монгол цэргийг тархааж шар болсон байна. Үүний урьд жил манан будан бүрхэж, нар цусан өнгөөр ургац цаг самуурахын шинж үзүүлсэн хийгээд Банчэн бээр байсан ч эс бичжээ. Арслан Хондон Балжирлхүндэвээс би Хөх нуурт очоод автайгаа уулзаж чадахаар байна уу? Эви аймгуудыг нэгтгээж чадах нь уу? Бүрхэг байна уу? гэж асуусанд одоо аав чинь сайн байна. Гэвч уулзалдахгүй, саад их байна гэжээ. Нинмаваагийн хараал гэж бодсон ч үнэн хэрэгтээ Данжсанчойжал уурлаад тайж өөрөө галзуурсан бөгөөд цэргүүд нь хямрах, урвах болсон аж. Нааш ирэх үедээ Цогт Гэлүгваад уурлан эцэг хүү хоёр уулзалдахгүй байхыг бодсон ч Повонхава болон Цэрсэв дүбчин нар Жигжидийн үүднээс ууртай сэтгэлийг тайвшруулах үйлийг зохиосноор тангараглалаа. Тавдугаар далай ламыг Гандан Хансарт залж өөрөө санаа нь эргээд хэнд ч мөргөж болохгүй гэсэн дотоод цаазыг эвдэн мөргөж адис хүртэв. Харилцан ярилцаж аль нь сайн байна гэх тэргүүтэн номын яриа айлтгасан байна. Урьд монголд Содномжамц далай ламын таалал барих үед эрдэнийн “Гачиг” гараад монгол оронд шашин дэлгэрэхийн бэлгэ дэмбэрэл гарсан адил болсон Дайчин түшмэл, шуумар Равжамба нар Цогтруу хун шлгээж хүү Арслан эцгийн зарлиг лугаа харшилсан тул явал зохистой гэж асуулгасанд аргаар хуурч ал гэж харилсан тул түүнийг аргаар алжээ. Гүүши хаан Дата-г номхотгон дарсан лугаа цаг нийцсэнээр Цогт сураггүй алга болсон¹¹ хэмээжээ.

Энэ сурвалжид өмнөх сурвалжуудад гарсан мэдээтэй агуулга адил мэдээ давтагдаж байна. Нэг онцлог нь Арслан тайж өөрийн ирэх үйлийг асууж лавласан тухай өгүүлснээс гадна Цогт тайж сураггүй алга болсон хэмээсэн нь өмнөх монгол болоод төвд сурвалжуудад огт тохиолдож байгаагүй билээ.

Эдгээр сурвалжийн мэдээг үзэхдээ зохиогчид нь ямар боловсролтой, бурханы шашны аль урсгалыг дэмжигч байсан гэдгийг нь сайтар судлаж байж дүгнэлт хийх нь зөв юм. Энэхүү өгүүлэлд ишлэл авсан сурвалжуудын хувьд зохиогчид нь шар малгайтны урсгалын лам хувраг байсан тул тэд Цогт хун тайжийг шарын шашны эсрэг боссон нэгэн хэмээсэн үзэлд автаж ном зохиолд нь ч тусгалаа олжээ.

Төвд сурвалжид гарч байгаа мэдээ баримтыг нэгтгэн дүгнэж үзвэл:

Нэгд. Цогт хун тайж нь халх халх орноосоо цөлөгдөж хөх нуурт ирснийг,

Хоёр. Шашныг өмгөөлөгч номын хаан Гүүши шарын шашинд чухал хөнөөл учруулагч Цогт хун тайжийг үлдэгдэлгүй дарсан гэх зэрэг мэдээ гарч байна. Харин төвд хүмүүсийн төвдөөр бичсэн сурвалжуудад Цогт хун тайжийн намтрыг огт дурдаагүй байна.

Төвд сурвалж бичигт Цогт хун тайж Хөх нуурын газар ирээд эхэн үедээ хүч чадалтай байсан хэдий ч шарын шашныг үгүй хийхээр муу санаа өвөрлөсөн тул санасан хэрэг нь бүтэлгүйтэж,

¹⁰ Аргын тооллын 1635 он.

¹¹ dbal'mang'pandi'tas'brtsams,rgya'bod'hor'sog'gi'lo'rgyus'nyung'ngur'brjod'pa'byis'pa'jug'pa'i''bab'stegs'bzhugs'so, mtsho'sngon'mi'rigs'dpe'skrun'khang, 1990. 137-140-р тал.

гал үхэр жилийн тэргүүн сард Гүүшри номын хаанд дарагдсан гэсэн ерөнхийдөө нэг агуулгатай мэдээ байна.

Бас зарим талаар анх төвд сурвалжид Цогт хун тайжийг шарын шашны эсрэг тэмцсэн гэж бичсэнээс хожим хойчийн сурвалж бичигч нар түүнийг даган баримталсаар ирсэн байж болох юм. Туган Лувсанчойжиням, Балманбандида нарын хувьд XVII, XIX зууны үед зохиол бүтээлээ бичиж туурвисан. Тэгвэл анх Цогт хун тайжийн тухай тэмдэглэсэн сурвалжууд энэ цаг хугацаанаас өмнө зохиогдсон байдаг тул өмнөх сурвалжуудаас эх авсан байж болох юм.

Тийм ч учраас өмнөх сурвалжийн мэдээг голлон ашигласан нь мэдээж хэрэг бөгөөд Монгол лам нарын туурвисан төвд хэлээрх сурвалжийн хувьд ч энэ нь хамаатай юм.

Resume

The yellow section of the Tibetan religion widely spread into Mongolia in the 17th and 18th centuries and under its influence the Mongolian learned people wrote their books in Tibetan. In the report we intended to write about the information and facts related to Tsogt khun taij mentioned in the Tibetan sources. So we first chose the works written by the Mongols in Tibetan. We made the following conclusions on the information mentioned in the Tibetan sources:

1. Tsogt khun taij is a grandson of Onokhui uizen noyon who was the son of Gersenz, the youngest son of Batmunkh dayan khan.
2. He was exiled from the land of Khalkh and came to the lake of Khukh nuur.
3. He, who made the damage to the yellow religion was defeated by Guush khan.

Номзүй

1. *Монгол улсын түүх*, гутгаар боть, (2003) Уб.,
2. *Монгол улсын түүх*, дөтгөөр боть, (2003) Уб.,
3. Бира Ш. (2001) *Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа*, Уб.,
4. Бүрнээ Д, Энхтөр Д. (2004) *Монголын бурханы шашны түүхэн сурвалж*, Уб.,
5. Бүрнээ Д, Энхтөр Д. (2001) *Төвд монгол толь бичиг*, Уб.,
6. Владимирцов.Б.Я, (1926, 1927) “*Надписи на скалах халхаского Цокту-тайджи*” Извятия Академии Наук СССР.,
7. Гонгор Д, (1970) *Халх товчоон I*, Уб.,
8. Дармадалаа, *Их Монгол оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оривой*, С.Гомбожавын орчуулга, (1995)Уб.,
9. Дашбадрах Д, (1998) “*Монгол-Түвэдийн улс тор, шашны харилцааны түүх*”, Уб.,
10. Лувсандаян, *сүмбүм ха (kha) боть*, УТНС шифр-3045.
11. Лувсанчүлтим, *сүмбүм жа (ca) боть brjed tho sna tshogs* УТНС шифр 4409/04.
12. “*Монголын түүхийн толь*”, (1999) Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.,
13. Пэрлээ Х, (2003) *Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудал*, Уб.,
14. Тэрбиш Л, Бямбаа Р, (1997) *Монголын түүх оривой*, Уб.,
15. *Цогт хун тайжид холбогдох бичгийн дурсгалууд*, (2005) Уб.,
16. Чоймаа Ш, *Монгол судлалын өгүүлүүд*, (2003) Уб.,
17. dbal'mang'pandi'tas'brtsams, rgya'bod'hor'sog'gi'lo'rgyus'nyung'ngur'brjod'pa'byis'pa 'jug'pa'i''bab'stegs'bzhugs'so, mtsho'sngon'mi'rigs'dpe'skrun'khang, 1990.
18. 'jigs med rig pa'i rdo rjes brtsams. hor gyi chos 'byung bzhugs so. Mtsho sngon mi rigs dpe skrun khang. 1993 zi ling.